



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд корона вирус
(COVID - 19) халдварын тархалтаас урьдчилан
сэргийлэх, хөл хорио тогтоох арга хэмжээний
үзүүлсэн нөлөөлөл

2021 оны 2-р сарын тандалт судалгаа

ОРШИЛ

ҮСХ-ноос цар тахлын халдварын тархалт ААН-ийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлж байгаа, тэдний орлого, үйлдвэрлэлд гарсан өөрчлөлт, ажлын байраа хадгалж буй байдал, ялангуяа Засгийн газар, Улсын онцгой комиссоос тухай бүр гаргаж буй шийдвэрийн хүрээнд үйл ажиллагаагаа хэрхэн удирдаж, төлөвлөж буйг тандан судалж байна.

Бид нэг дэх шатны судалгааг 2020 оны 5-р сарын 6-наас 20-ны өдрүүдэд, II шатны судалгааг 7-р сарын 27-ноос 8-р сарын 10-ны өдрүүдэд, III дахь шатны судалгааг 12-р сарын 15-наас 28-ны өдрүүдэд тус тус зохион байгуулж явуулсан. 2021 оны 2-р сарын судалгааны мэдээлэл цуглуулалтыг 3-р сарын 1-нээс 10-ны өдрүүдэд зохион байгуулав.

Энэ удаагийн судалгаанд “Бүх нийтийн болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг”-т шилжсэн нь ААН-ийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлж байгааг 2020 онд хийсэн гурван шатны судалгаа болон 2021 оны 1-р сард хийсэн судалгааны үр дүнтэй харьцуулав.

“Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд Корона вируст (Covid 19) халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоох арга хэмжээний үзүүлсэн нөлөөлөл” 2021 оны 2-р сарын тандалт судалгаанд үйл ажиллагаа явуулж байгаа нийт 2431 аж ахуйн нэгж хамрагдсан.

ХҮСНЭГТ 1. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ, салбарын ангиллаар, дүнд эзлэх хувиар, 2020 оны жилийн эцсийн байдлаар

Үйл ажиллагааны чиглэл	ААН-ийн тоо	Дүнд эзлэх хувь
Бүгд	94 491	100.0
Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	37 784	40.0
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	9 021	9.5
Барилга	7 651	8.1
Боловсруулах үйлдвэрлэл	6 355	6.7
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	5 382	5.7
Боловсрол	4 580	4.8
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	3 441	3.6
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	3 250	3.4
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	2 758	2.9
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	2 361	2.5
Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	2 314	2.4
Мэдээлэл, холбоо	2 014	2.1
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	1 797	1.9
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	1 596	1.7
Уул уурхай, олборлолт	1 287	1.4
Урлаг, үзвэр, тоглоом наадам	1 240	1.3
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	1 165	1.2
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	264	0.3
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	195	0.2
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	36	0.0

Монгол улсад корона вируст (Covid 19) халдвар бүртгэгдсэн анхны тохиолдлоос эхлэн Засгийн газраас халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, хүний эрхэд тодорхой хязгаарлалт хийх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зэрэг арга хэмжээг зохион байгуулж байна. Монгол Улсын Засгийн газраас :


- Засгийн газрын 2020 оны 1-р сарын 4-ний өдрийн 1 дүгээр тогтоолоор 1-р сарын 11-нийг дуустал,
- Засгийн газрын 27 дугаар тогтоолоор 2-р сарын 11-нээс 23-ны өдрийг хүртэл хэсэгчилсэн байдлаар нийслэл Улаанбаатар хотод “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлэх шийдвэрийг гаргасан.

ЗУРАГ 2. ХАТУУ ХӨЛ ХОРИО ТОГТООСОН ҮЕ, хугацаагаар



Судалгаанд хамрагдсан нийт аж ахуйн нэгжийн 43.6% нь 2021 оны 2-р сард үйл ажиллагаа хэвийн явагдаж байна, 56.4% нь хэвийн явагдахгүй байна гэсэн хариулт өгчээ. Өмнөх сард явагдсан тандалт судалгааны үр дүнтэй харьцуулахад үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байгаа ААН-ийн эзлэх хувь 7.4 пунктээр нэмэгдсэн байна.

ЗУРАГ 1. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, судалгаа явагдсан хугацаагаар



Корона вируст халдварын тархалт эхэлж, анх удаа хатуу хөл хорио тавигдаж эхэлсэн үетэй харьцуулахад үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байгаа ААН-ийн эзлэх хувь 2021 оны 2-р сард 2.7 пунктээр буурсан байна.

Үйл ажиллагаа нь хэвийн явагдсан ААН-ийн эзлэх хувь хатуу хөл хорио харьцангуй сул буюу бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хэдий ч эдийн засгийн салбаруудын үйл ажиллагаа нээлттэй байсан үе буюу өмнөх оны 3-р улиралд 50 хувиас давжээ.

Мөн 2020 оны 11-р сараас эхэлсэн “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлсэн хугацаанд дийлэнх салбаруудын үйл ажиллагаа хаагдсаны үр нөлөөгөөр 2020 оны төгсгөл болон 2021 оны 1-р сард үйл ажиллагаа нь хэвийн явагдсан ААН-ийн эзлэх хувь хамгийн бага түвшинд буюу 34.6% - 36.2%-д хүрсэн байна.

Үйл ажиллагаа нь хэвийн явагдахгүй байгаа ААН-ийн 21.9% нь улирлын чанартай үйл ажиллагаа эрхэлдэг ААН-үүд байна.

Үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байгаа 1061 аж ахуйн нэгжийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар (Хүснэгт 2) харуулбал:

- 291 (33.1%) нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбар,
- 119 (13.5%) нь боловсруулах үйлдвэрлэлийн салбар,
- 75 (8.5%) нь хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа,
- 62 (7.1%) нь зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ,
- 59 (6.7%) нь хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбар,
- 273 (31.1%) нь барилга, мэргэжлийн шинжлэх ухаан болон техник, боловсрол, тээвэр агуулах, санхүүгийн болон даатгал, мэдээлэл холбоо, цахилгаан, хий, агааржуулалт, уул уурхай, олборлолт, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх, ус хангамж: сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх, аялал жүүлчлал, урлаг, үзвэр, тоглоом, үйлчилгээний бусад үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүд байна.

Бөөний болон жижиглэн худалдааны үйл ажиллагаа эрхэлдэг 591 ААН-ийн 41.1 хувь нь “Үйл ажиллагаа хэвийн явагдахгүй байна” гэж хариулжээ. Түүнчлэн:

- Боловсролын үйл ажиллагаа эрхэлдэг 161 ААН-ийн 82.6 хувь,
- Барилгын үйл ажиллагаа эрхэлдэг 217 ААН-ийн 75.1 хувь,
- Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ эрхэлдэг 259 ААН-ийн 71.8 хувь,
- Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын үйл ажиллагаа эрхэлдэг 157 ААН-ийн 68.8 хувь,

Боловсруулах үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхэлдэг 296 ААН-ийн 50.7 хувь нь үйл ажиллагаа хэвийн явагдахгүй байна гэсэн хариултыг өгсөн байна.


ХҮСНЭГТ 2. СУДАЛГААНД ХАМРАГДСАН АЖ АХУЙН НЭГЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ,
эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, өмнөх судалгаануудын үр дүнтэй харьцуулснаар

Салбар	Хэвийн					Хэвийн бус				
	2020 I шат	2020 II шат	2020 III шат	2021 I сар	2021 II сар	2020 I шат	2020 II шат	2020 III шат	2021 I сар	2021 II сар
Бүгд	1 113	1 255	826	879	1 061	1 289	1 147	1 562	1 552	1370
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	96	97	70	59	49	65	64	91	98	108
Уул уурхай, олборлолт	16	16	11	22	25	15	15	20	31	28
Боловсруулах үйлдвэрлэл	112	99	79	119	146	106	119	139	177	150
Цахилгаан, хий, агааржуулалт	15	10	13	29	29	7	5	2	5	5
Ус хангамж: Сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	7	7	8	7	7	2	2	1	0	0
Барилга	93	117	34	42	54	105	81	164	175	163
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	289	350	257	291	348	268	207	300	300	243
Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	47	45	30	43	61	69	71	86	89	71
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	63	103	45	62	73	156	116	174	197	186
Мэдээлэл, холбоо	11	16	15	19	21	18	13	14	12	10
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	53	49	24	45	52	29	33	58	52	45
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	38	33	12	14	16	39	44	65	62	60
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	35	35	33	16	32	37	37	39	60	44
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	15	20	10	5	17	17	12	22	26	14
Аялал жуулчлал	6	5	7	5	8	66	67	65	63	60
Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмы нийгмийн даатгал	12	11	-	-	-	2	3	-	-	-
Боловсрол	48	90	31	22	28	157	115	174	139	133
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	76	80	74	75	81	39	35	41	34	28
Урлаг, үзвэр, тоглоом	9	16	2	0	7	30	23	37	24	17
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	79	56	71	4	7	62	85	70	8	5

Судалгаанд “Үйл ажиллагаа хэвийн явагдахгүй байгаа” гэсэн хариулт өгсөн 1370 аж ахуйн нэгжийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар харуулбал:

- 243 (17.7%) нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбар,
- 186 (13.6%) нь зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбар,
- 163 (11.9%) нь барилгын салбар,
- 150 (10.9%) нь боловсруулах үйлдвэрлэлийн салбар,
- 133 (9.7%) нь боловсролын салбар,
- 108 (7.9%) нь хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбар,
- 387 (28.2%) нь тээвэр, агуулах, үйлчилгээний бусад, аялал жуулчлал, үл хөдлөх хөрөнгө, санхүүгийн болон даатгал, хүний эрүүл мэнд, нийгмийн халамж, мэргэжлийн шинжлэх ухаан болон техник, урлаг, үзвэр, тоглоом, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх, уул уурхай, олборлолт, мэдээлэл холбоо, цахилгаан, хий, агааржуулалт, ус хангамж: сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх зэрэг үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүд байна.

ЗУРАГ 3. ҮЙЛ АЖИЛЛАГАА ХЭВИЙН ЯВАГДАХГҮЙ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ, салбараар, 2021 оны 2-р сард



СУДАЛГААНЫ ҮР ДҮН

1. ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ЯВУУЛАХАД УЧИРЧ БУЙ ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ

Монгол Улсын Засгийн газраас “Бүх нийтийн болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг”, “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлсэн шийдвэртэй холбогдуулан “Үйл ажиллагаа нь хэвийн бус” гэж хариулсан 1370 ААН-ийн 922 (67.3%) нь үйл ажиллагаа нь хүндэрсэн гэж хариулжээ.

Энэ нь өмнөх 1-р сард явагдсан судалгааны үр дүнтэй харьцуулахад 16.0 пунктээр буурсан байна. Үйл ажиллагаа нь хүндэрсэн аж ахуйн нэгжийн тоо буурахад цагаан сарын баяр хүртэлх үе, цагаан сарын дараах үеүдэд ихэнх салбарын үйл ажиллагаа нээхийг зөвшөөрсөн шийдвэр гаргасан нь нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 3. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХАД УЧИРЧ БУЙ ХҮНДРЭЛ, хамгийн их давтагдсан 5 шалтгаанаар, 2020 онд явагдсан 3 шатны судалгааны үр дүнгээр

№	2020 I шат		2020 II шат		2020 III шат	
	Шалтгаан	Дүнд эзлэх хувь	Шалтгаан	Дүнд эзлэх хувь	Шалтгаан	Дүнд эзлэх хувь
1	Санхүүгийн байдал хүндэрсэн	48.2	Санхүүгийн байдал хүндэрсэн	43.8	Санхүүгийн байдал хүндэрсэн	55.5
2	Үйлчлүүлэгчийн тоо эрс буурсан	44.9	Үйлчлүүлэгчийн тоо эрс буурсан	37.2	Хатуу хөл хорио дуустал үйл ажиллагаагаа түр зогсоосон	47.2
3	Ажиллагчдынхаа цалинг олгох, НДШ-ийг төлөхөд хүндрэлтэй болсон	27.8	Корона вирусээс (Covid-19) урьдчилан сэргийлэх арга хэмжээ, хөл хорио тавигдтал үйл ажиллагаагаа түр зогсоосон	36.3	Үйлчлүүлэгчийн тоо эрс буурсан	41.4
4	ААН-ийн орлогын албан татвар, бусад татвар хураамжийг төлөхөд хүндрэлтэй болсон	24.1	Үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээ эрс буурсан	22.8	Ажиллагчдынхаа цалинг олгох, НДШ-ийг төлөхөд хүндрэлтэй болсон	31.7
5	Зээл, зээлийн хүүг төлөхөд хүндрэлтэй болсон	23.8	Ажиллагчдынхаа цалинг олгох, НДШ-ийг төлөхөд хүндрэлтэй болсон	20	Зээл, зээлийн хүү төлөхөд хүндрэлтэй болсон	27.2

2021 оны 2-р сарын судалгаанд 14 хоногийн хугацаанд тогтоосон хатуу хөл хорионоос шалтгаалан үйл ажиллагаа нь хүндэрсэн гэж хариулсан ААН-ийн дийлэнх нь буюу 71.1% нь “Санхүүгийн байдал хүндэрсэн” гэсэн хариултыг өгсөн байна. Энэ нь өмнөх сард явуулсан “ААН-ийн үйл ажиллагаанд Корона вируст халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоох арга хэмжээний үзүүлсэн нөлөөллийн тандалт судалгаа”-ны үр дүнтэй харьцуулахад 1.4 пунктээр буурсан байна.

ХҮСНЭГТ 4. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХАД УЧИРЧ БҮЙ ХҮНДРЭЛ, хамгийн их давтагдсан 5 шалтгаанаар, 2021 оны 1-р сарын судалгааны үр дүнтэй харьцуулснаар

№	2021 I сар		2021 II сар	
	Шалтгаан	Дүнд эзлэх хувь	Шалтгаан	Дүнд эзлэх хувь
1	Санхүүгийн байдал хүндэрсэн	72.5	Санхүүгийн байдал хүндэрсэн	71.1
2	Үйлчлүүлэгчийн тоо эрс буурсан	58.7	Үйлчлүүлэгчийн тоо эрс буурсан	60.5
3	Ажиллагчдынхаа цалинг олгох, НДШ-ийг төлөхөд хүндрэлтэй болсон	44.3	Ажиллагчдынхаа цалинг олгох, НДШ-ийг төлөхөд хүндрэлтэй болсон	41.6
4	Үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээ эрс буурсан	37.1	Үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээ эрс буурсан	33.1
5	ААН-ийн орлогын албан татвар, бусад татвар хураамжийг төлөхөд хүндрэлтэй болсон	34.4	ААН-ийн орлогын албан татвар, бусад татвар хураамжийг төлөхөд хүндрэлтэй болсон	32.2

2020 онд явагдсан 3 шатны судалгаанд “Санхүүгийн байдал хүндэрсэн”, “Үйлчлүүлэгчийн тоо эрс буурсан” гэсэн шалтгаануудыг судалгаанд хамрагдсан ААН-ийн олонх нь дурдаж байсан бол энэ оны судалгаанд мөн дээрх байдал хэвээр хадгалагдаж байна. Энэ нь “Бүх нийтийн болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлж, хатуу хөл хорио тогтоосон хугацаанд ААН-үүдийн санхүүгийн байдал хугацаа өнгөрөх тусам муудсаар байгааг харуулж байна.

ХҮСНЭГТ 5. ААН-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХАД УЧИРЧ БҮЙ ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ, шалтгаанаар


Үйл ажиллагааны чиглэл	ААН-ийн тоо	ААН-ийн дүнд эзлэх хувь
Санхүүгийн байдал хүндэрсэн	656	71.1
Үйлчлүүлэгчийн тоо эрс буурсан	558	60.5
Ажиллагчдынхаа цалинг олгох, НДШ-ийг төлөхөд хүндрэлтэй болсон	384	41.6
Үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээ эрс буурсан	305	33.1
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, бусад татвар, хураамжийг төлөхөд хүндрэлтэй болсон	297	32.2
Зээл, зээлийн хүү төлөхөд хүндрэлтэй болсон	283	30.7
Түүхий эд материал, барааны эргэлт удааширч, хомсдол үүссэн	229	24.8
Түрээсийн төлбөрөө төлөхөд хүндрэлтэй болсон	225	24.4
Төлөвлөсөн хөрөнгө оруулалт хийгдээгүй, хойшлогдсон	142	15.4
Бусад	115	12.5
Ажиллагчдын тоог бууруулсан	114	12.4
Бусад төлбөр төлөхөд хүндрэлтэй болсон (ус, цахилгаан, дулаан гэх мэт)	113	12.3

Тайлбар: Хариулт нь олон сонголттой бөгөөд олон давтагдсанаар нь эрэмбэлсэн.

2. ОРЛОГОД ҮЗҮҮЛСЭН НӨЛӨӨ

Үйл ажиллагаанд нь хүндрэл учирсан гэж хариулсан 922 ААН-ийн дийлэнх нь буюу 728 (79.0%) нь Монгол Улсын Засгийн газраас “Бүх нийтийн болон Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлснээс шалтгаалан 2-р сард өмнөх сараас “Орлого буурсан” гэж хариулсан бол 194 (21.0%) нь өмнөх сараас орлого буураагүй гэж хариулсан байна. Орлого буурсан ААН-ийн эзлэх хувь өмнөх сарын судалгааны үр дүнтэй харьцуулахад 10.8 пунктээр буурсан байна.

ЗУРАГ 4. ОРЛОГО БУУРСАН ААН-ИЙН НИЙТ ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, орлогын бүлгээр, өмнөх судалгаануудын үр дүнтэй харьцуулснаар



2021 оны 2-р сард үйл ажиллагаа нь хүндэрч “Орлого буурсан” 922 ААН-ийг бүлэглэж авч үзвэл, орлого нь 50-иас дээш хувиар буурсан ААН 61.1 хувь, 41-50 хувиар буурсан ААН 10.6 хувь, 31-40 хувиар буурсан ААН 10.3 хувь, 21-30 хувиар буурсан ААН 9.2 хувь, 11-20 хувиар буурсан ААН 6.2 хувь, 10 хүртэл хувиар

буурсан ААН 2.6 хувийг тус тус эзэлж байна. Өмнөх сарын судалгааны үр дүнтэй харьцуулахад 50-иас дээш хувиар орлого буурсан ААН-ийн эзлэх хувь 0.5 пунктээр нэмэгдсэн бол орлого нь 10 хүртэл хувиар буурсан ААН-ийн эзлэх хувь 0.8 пунктээр буурсан байна.

2020 оны 3-р сард манай улсад анх Корона вируст халдвар бүртгэгдэж эхэлж байх үед судалгаанд хамрагдсан ААН-ийн 43.7 хувийнх нь орлого 50-иас дээш хувиар буурч байсан бол энэ байдал хугацаа өнгөрөх тусам улам гүнзгийрсэн байдал ажиглагдаж байна.

2021 оны 2-р сард орлого нь 50-иас дээш хувиар буурсан ААН-ийн эзлэх хувь 2020 оны эхний шатны судалгааны үр дүнтэй харьцуулахад 17.4 пунктээр өсжээ.

Засгийн газраас “Бүх нийтийн болон Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлснээс шалтгаалан 2021 оны 2-р сард орлого буурсан 728 аж ахуйн нэгжийг салбараар харуулбал,

- 145 (19.9%) нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ,
- 123 (16.9%) нь зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбар,
- 83 (11.4%) нь боловсролын салбар,
- 80 (11.0%) нь боловсруулах үйлдвэрлэлийн салбар,
- 46 (6.3%) нь барилгын салбар,
- 45 (6.2%) нь тээвэр, агуулахын салбар,
- 45 (6.2%) нь үл хөдлөх хөрөнгийн салбар,
- Үлдсэн 161 (22.1%) нь санхүүгийн болон даатгалын, хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур, мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн, хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн, аялал жуулчлал, уул уурхай, олборлолтын, урлаг, үзвэр, тоглоом, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх, мэдээлэл, холбоо, үйлчилгээний бусад, цахилгаан, хий, агааржуулалтын зэрэг салбаруудад үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүд байна.


ХҮСНЭГТ 6. ӨМНӨХ САРААС ОРЛОГО БУУРСАН АЖ АХУЙН НЭГЖИЙН ТОО, дүнд эзлэх хувиар, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар

Үйл ажиллагааны чиглэл	ААН-ийн тоо	Дүнд эзлэх хувь
Бүгд	728	100.0
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	145	19.9
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	123	16.9
Боловсрол	83	11.4
Боловсруулах үйлдвэрлэл	80	11.0
Барилга	46	6.3
Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	45	6.2
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	45	6.2
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	39	5.4
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	25	3.4
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	22	3.0
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	19	2.6
Аялал жуулчлал	15	2.1
Уул уурхай, олборлолт	11	1.5
Урлаг, үзвэр, тоглоом	11	1.5
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	9	1.2
Мэдээлэл, холбоо	5	0.7
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	3	0.4
Цахилгаан, хий, агааржуулалт	2	0.3

3. ҮЙЛДВЭРЛЭЛД ҮЗҮҮЛСЭН НӨЛӨӨ

Засгийн газраас “Бүх нийтийн болон Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлсэнтэй холбоотойгоор 2021 оны 2-р сард үйл ажиллагаанд нь хүндрэл учирсан 922 ААН-ийн 699 буюу 75.8 хувийнх нь үйлдвэрлэл өмнөх сараас буурсан бол 223 ААН буюу 24.2 хувь нь үйлдвэрлэл буураагүй гэсэн хариулт өгчээ.

ЗУРАГ 5. ҮЙЛДВЭРЛЭЛ БУУРСАН АЖ АХУЙН НЭГЖИЙН НИЙТ ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, бүлгээр, өмнөх шатны судалгаануудын үр дүнтэй харьцуулснаар



Үйлдвэрлэл нь 2021 оны 2-р сард өмнөх сараас буурсан нийт ААН-ийн дийлэнх буюу 62.1 хувийнх нь үйлдвэрлэл 50-иас дээш хувиар, 10.6 хувь нь 41-50 хувиар, 10.9 хувь нь 31-40 хувиар, 10.3 хувь нь 21-30 хувиар, 4.1 хувь нь 11-20 хувиар, 2.0 хувь нь 10 хүртэл хувиар үйлдвэрлэл буурсан гэж тус тус хариулсан байна.


Үйлдвэрлэлийн бууралтын хувийг 2020 оны 3 дахь шатны судалгааны үр дүнтэй харьцуулахад 50-иас дээш хувиар буурсан ААН-ийн эзлэх хувь 0.3 пунктээр, 41-50 хувиар буурсан ААН-ийнх 3.1 пунктээр, 10 хүртэл хувиар буурсан ААН-ийнх 0.1 пунктээр тус тус буурсан бол 11-31-40 хувиар буурсан ААН-ийн эзлэх хувь 0.8 пунктээр, 21-30 хувиар буурсан ААН-ийнх 1.6 пунктээр, 11-20 хувиар буурсан ААН-ийнх 1.2 пунктээр тус тус өссөн байна.

Үйл ажиллагаанд нь хүндрэл учирч үйлдвэрлэл, орлого нь 50-иас дээш хувиар буурсан ААН-үүдийн эзлэх хувь хатуу хөл хорио тогтоож эхэлсэн үеэс хойш тогтмол 60 хувиас давсан байна. Энэ нь орлогын буурч байдал гүнзгийрсээр байгааг харуулж байна.

4. ЦАЛИН БУУРУУЛСАН БАЙДАЛ

Үйл ажиллагаанд нь хүндрэл учирсан 922 ААН-ийн 421 (45.7%) нь ажиллагчдынхаа цалинг бууруулсан бол 501 (54.3%) нь цалингаа бууруулах арга хэмжээ аваагүй байна.

ЗУРАГ 6. ЦАЛИН БУУРУУЛСАН ААН, бүлгээр, дүнд эзлэх хувь



Энэ нь өмнөх сард явагдсан судалгааын үр дүнтэй харьцуулахад цалинг ажилласан цагаар нь (хийснээр нь) олгосон ААН-ийн эзлэх хувь 0.8 пунктээр буурсан бол цалингаа 50-иас дээш хувиар бууруулсан ААН-ийн эзлэх хувь 9.7 пунктээр өссөн байна. Харин 10 хүртэл хувиар бууруулсан ААН-ийн эзлэх хувь 0.1 пунктээр буурсан байна.

5. АЖИЛЛАГЧДАДАА ЦАЛИНТАЙ ЧӨЛӨӨ ОЛГОЖ, ЗАЙНААС АЖИЛЛАХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛСЭН БАЙДАЛ

ХҮСНЭГТ 7. ЦАЛИНТАЙ ЧӨЛӨӨ ОЛГОЖ, ЗАЙНААС АЖИЛЛАХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛСЭН БАЙДАЛ, өмнөх судалгаануудын үр дүнтэй харьцуулснаар

	Дүнд эзлэх хувь				
	2020 I шат	2020 II шат	2020 III шат	2021 I сар	2021 II сар
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0
Цалинтай чөлөө олгож, зайнаас ажиллах нөхцөл, боломж бүрдүүлсэн	33.9	37.3	41.4	39.0	18.4
Цалинтай чөлөө олгож, зайнаас ажиллах нөхцөл, боломж бүрдүүлээгүй	66.1	62.7	58.6	61.0	81.6

Засгийн газраас “Бүх нийтийн болон Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлсэн хугацаанд судалгаанд хамрагдаж үйл ажиллагаанд нь хүндрэл учирсан аж ахуйн нэгжийн 18.4% нь ажиллагчдадаа цалинтай чөлөө олгож, зайнаас ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлсэн бол 81.6% нь буюу дийлэнх нь ажиллагчдадаа цалинтай чөлөө олгож, гэрээсээ ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлээгүй байна.

Корона вирусний халдвар бүртгэгдэж эхэлсэн үе буюу 2020 оны I шатны судалгаанд хамрагдсан, үйл ажиллагаа нь хэвийн бус гэж хариулсан ААН-үүдийн 33.9 хувь нь ажиллагчдаа зайнаас ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлж байсан бол энэ байдал 2020 оны 2, 3, 4-р улиралд харьцангуй нэмэгдэж оны сүүлээр 7.5 пунктээр өссөн бол энэ оны 2-р сард 15.5 пунктээр буурсан байна. ААН-үүдийн орлого, үйлдвэрлэл буурч, үйл ажиллагаанд нь учирч буй хүндрэл эрс нэмэгдсэн байдал нь ААН-үүдийн хувьд ажиллагчдаа гэрээсээ ажиллах нөхцлийг бүрдүүлэх боломжийг бууруулж байгаа бөгөөд мөн цалин, НДШ-ийг төлөхөд хүндрэлтэй болсон зэргээс шалтгаалсан байна.

Ажиллагчдадаа цалинтай чөлөө олгож, зайнаас ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлсэн ААН-үүдээс энэ арга хэмжээгээ одоо үргэлжлүүлж буй эсэхийг асуухад 58.2% нь тийм, 41.8% нь үгүй гэж хариулсан байна.

Корона вирусний тархалт дэлхий нийтээр эрчимтэй явагдаж, эхний давлагаа хүчтэй өрнөж байх үед судалгаанд хамрагдсан нийт ААНБ-ын 37.3 хувь нь ажиллагчдадаа цалинтай чөлөө олгож, гэрээсээ ажиллах нөхцөлийг бүрдүүлж байсан бол 2021 оны 2-р сард судалгаанд хамрагдаж, үйл ажиллагаа нь хүндэрсэн нийт ААН-ийн 58.2 хувь нь тус арга хэмжээг үргэлжлүүлэн авч хэрэгжүүлж байна.


6. ЗАСГИЙН ГАЗРЫН ШИЙДВЭРЭЭС ШАЛТГААЛАН ААН-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ

ЗУРАГ 7. ААН-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ

Судалгаанд хамрагдсан 2431 ААН-ийн олонх буюу 922 (37.9%) нь “Өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлсэнтэй холбогдуулан үйл ажиллагаа нь хүндэрсэн байна.

Эдгээр ААН-ийн 844 (91.5%) нь “Тэг зогсолт” хийсэн бол 75 (8.1%) нь хэсэгчлэн үйл ажиллагаа явуулж, 3 (0.3%) нь үйл ажиллагаагаа хэвийн явуулсан гэсэн хариултыг өгсөн байна.


Энэ нь өмнөх сард явагдсан тандалт судалгааны үр дүнтэй харьцуулахад “Тэг зогсолт” хийсэн ААН-ийн эзлэх хувь 50.7 пунктээр өсжээ.



“Хэсэгчлэн үйл ажиллагаа явуулсан ААН-ийн эзлэх хувь 29.5 пунктээр, хэвийн ажилласан ААН-ийн эзлэх хувь 21.3 пунктээр тус тус буурсан байна.

7. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАГЧДЫН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ

ЗУРАГ 8. ААН-ИЙН ТОО, АЖИЛЛАГЧДЫН ТООНЫ БҮЛГЭЭР, ХУВИАР




Судалгаанд хамрагдсан нийт ААН-ийн дийлэнх буюу 1735 (71.4%) нь 1-9 ажиллагчидтай, 296 (12.2%) нь 10-19 ажиллагчидтай, 208 (8.6%) нь 20-49 ажиллагчидтай, 192 (7.9%) нь 50-иас дээш тооны ажиллагчидтай ААН-үүд байна.

ЗУРАГ 9. АЖИЛЛАГЧДАА ЦОМХОТГОСОН ААН

Судалгаанд хамрагдсан нийт ААНБ-ын 208 (8.6%) нь Засгийн газраас “Бүх нийтийн болон Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлсэнтэй холбоотойгоор үйл ажиллагаа нь хүндэрч, ажиллагчдаа цомхотгох арга хэмжээ авсан бол 2223 (91.4%) нь цомхотгол хийгээгүй байна.

Үүнээс харахад судалгаанд хамрагдсан ААН-ийн дийлэнх нь буюу 91.4% нь ажиллагчдаа цаашид цомхотгохгүйгээр ажиллуулах хүсэл эрмэлзэлтэй байгаа байдал ажиглагдаж байна.



ХҮСНЭГТ 8. ЦОМХОТГОЛ ХИЙСЭН ААН, ЦОМХОТГОСОН АЖИЛЛАГЧДЫН ТООНЫ БҮЛГЭЭР

Ажиллагчдаа цомхотгосон 208 ААН-ийг цомхотгосон ажиллагчдын тооны бүлгээр задалж авч үзвэл, дийлэнх буюу 1-9 хүртэл ажиллагчдаа цомхотгосон 182 ААН буюу 87.5 хувь, 10-19 хүртэл ажиллагчдаа цомхотгосон 17 ААН буюу 8.2 хувь, 20-29 ажиллагчдаа цомхотгосон 2 ААН буюу 1.0 хувь, 30-39 ажиллагчдаа цомхотгосон 4 ААН буюу 1.9 хувь, 40-өөс дээш тооны ажиллагчдаа цомхотгосон 3 ААН буюу 1.4 хувийг тус тус эзэлж байна.

	2021 I		2021 II	
	ААН-ийн тоо	Дүнд эзлэх хувь	ААН-ийн тоо	Дүнд эзлэх хувь
Бүгд	286	100.0	208	100.0
1-9 ажиллагч	252	88.1	182	87.5
10-19 ажиллагч	15	5.2	17	8.2
20-29 ажиллагч	10	3.5	2	1.0
30-39 ажиллагч	5	1.7	4	1.9
40-өөс дээш ажиллагч	4	1.4	3	1.4

**ХҮСНЭГТ 9. АЖИЛЛАГЧДАА ЦОМХОТГОХГҮЙ БАЙХ
БОЛОМЖТОЙ ХУГАЦАА, бүлгээр**

	2021 I	2021 II
	Дүнд эзлэх хувь	
3 хүртэлх сар	13.2	14.1
3 – 6 сар	6.5	6.9
6 – 12 сар	3.2	2.6
Цомхотгол хийхгүй	43.2	45.2
Тодорхойгүй	33.9	31.2

Цаашид ямар хугацаанд ажиллагчдаа цомхотгохгүй байх боломжтой эсэхийг тодруулан асуухад, судалгаанд хамрагдсан нийт ААН-ийн олонх нь буюу 1099 (45.2%) нь цомхотгол хийхгүй гэж хариулсан бол 759 (31.2%) нь тодорхойгүй, 342 (14.1%) нь 3 хүртэл сарын хугацаанд цомхотгол хийхгүй, 168 (6.9%) нь 3-6 сар хүртэлх хугацаанд цомхотгол хийхгүй, хамгийн бага буюу 63 (2.6%) нь 6-12 сар хүртэлх хугацаанд цомхотгол хийхгүй байх боломжтой гэж хариулсан байна.

Энэ нь өмнөх сард явуулсан судалгааны үр дүнтэй харьцуулахад “Тодорхойгүй” гэж хариулсан ААН-ийн эзлэх хувь 2.7 пунктээр буурсан бол “Цомхотгол хийхгүй” гэж хариулсан ААН-ийн эзлэх хувь 2.0 пунктээр нэмэгдсэн байна.

8. АЖ АХУЙН НЭГЖИД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ

Монгол Улсын Засгийн газраас “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлсэн хугацааг үргэлжлүүлж, сунгавал ААН-ийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлөх талаар тодруулахад, судалгаанд хамрагдсан нийт ААН-ийн дийлэнх буюу 1392 (57.3%) нь маш их сөрөг нөлөөтэй, 648 (26.7%) нь дунд зэрэг сөрөг нөлөөтэй, 243 (10.0%) нь бага зэрэг сөрөг нөлөөтэй, 148 (6.1%) нь ямар нэг нөлөө үзүүлэхгүй гэж хариулсан байна.

**ХҮСНЭГТ 10. ХӨЛ ХОРИОГ ҮРГЭЛЖЛҮҮЛЭХЭД ААН-ИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ**

Энэ нь өмнөх сард явагдсан судалгааны үр дүнтэй харьцуулахад “Маш их сөрөг нөлөөтэй” гэж хариулсан ААН-ийн эзлэх хувь 1.2 пунктээр, “Ямар нэг нөлөө үзүүлээгүй” гэж хариулсан ААН-ийн эзлэх хувь 1.2 пунктээр тус тус өссөн бол “Дунд зэрэг сөрөг нөлөөтэй” гэж хариулсан ААН-ийн эзлэх хувь 0.2 пунктээр, “Бага зэрэг сөрөг нөлөөтэй” гэж хариулсан ААН-ийн эзлэх хувь 2.1 пунктээр тус тус буурсан байна.


	2021 I	2021 II
	Дүнд эзлэх хувь	
Маш их сөрөг нөлөөтэй	56.1	57.3
Дунд зэрэг сөрөг нөлөөтэй	26.9	26.7
Бага зэрэг сөрөг нөлөөтэй	12.1	10.0
Ямар нэг нөлөө үзүүлэхгүй	4.9	6.1

9. ҮЙЛ АЖИЛЛАГАА ХЭВИЙН ЯВУУЛАХАД ШААРДАГДАХ ХУГАЦАА

Судалгаанд хамрагдсан 2431 ААН-ээс Корона вируст (Covid 19) халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоох арга хэмжээ тавигдсанаас хойш үйл ажиллагаагаа хэвийн явуулахад шаардагдах хугацааны талаар тодруулсан.

Судалгаанд хамрагдсан нийт ААН-ийн 623 (25.6%) нь 3 сар хүртэл, 405 (16.7%) нь 3-6 сар хүртэл, 193 (7.9%) нь 6-12 сар хүртэл, 152 (6.3%) нь 1 жилээс дээш хугацаа шаардагдана гэж хариулсан байна. Харин 606 (24.9%) нь үйл ажиллагаагаа хэвийн явуулж эхлэх хугацаа тодорхойгүй гэж хариулсан бол 452 (18.6%) нь хэвийн ажиллаж байгаа гэсэн хариултыг өгсөн байна.

ЗУРАГ 10 . ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ХЭВИЙН ЯВУУЛАХАД ШААРДАГДАХ ХУГАЦАА, ААН-ийн эзлэх хувиар



10. ААН-ЭЭС ӨГСӨН ЗАСГИЙН ГАЗРААС ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ

Судалгаанд хамрагдсан ААН-ийн хувьд төрөөс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзсэн байна. Үүнд:

- Зээл авах боломжийг бий болгох бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх – 1456
- Үйл ажиллагаагаа сэргээхэд гарах асуудлуудыг төрийн бодлогоор шуурхай шийдэхэд дэмжлэг үзүүлэх - 1318
- Эрсдэл, гамшгийн үед ААН-ийн үйл ажиллагаа эдийн засагт учирч болох болзошгүй аюулаас сэргийлэх, даван туулах стратеги, бодлогыг боловсруулах – 1071
- Бусад – 129

Бусад шалтгаантай ААН-ийн саналыг олон давтагдсан байдлаар нь эрэмбэлж авч үзвэл, зээлийн хүүг бууруулах, бага хүүтэй, хөнгөлөлттэй зээл олгох, НӨАТ, НДШ, ААНОАТ-ыг тэглэх, татварын хөнгөлөлт үзүүлэх, хөл хориог цуцалж, вакцинжуулалтыг эхлүүлж, яаралтай хэвийн горимд шилжүүлэх зэрэг саналуудыг өгсөн байна.

ДҮГНЭЛТ

Засгийн газраас Корона вируст (Covid 19) халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоох арга хэмжээний нөлөөгөөр судалгаанд хамрагдсан 2431 аж ахуйн нэгжийн 56.4% буюу олонх нь хэвийн явагдахгүй байна гэсэн хариулт өгчээ.

Үйл ажиллагаа нь хэвийн явагдахгүй байгаа нийт аж ахуйн нэгжийг салбараар авч үзвэл, дараах салбарууд хамгийн их өртсөн байна. Үүнд:

- 19.3% нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбар,
- 12.7% нь зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбар,
- 11.4% нь боловсруулах үйлдвэрлэлийн салбар,
- 11.3% нь барилгын салбар,
- 9.0% нь боловсрол зэрэг салбарууд байна.

Монгол Улсын Засгийн газраас “Бүх нийтийн болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг”, “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлсэн шийдвэртэй холбогдуулан “Үйл ажиллагаа нь хэвийн бус” гэж хариулсан 1370 ААН-ийн 922 (67.3%) нь үйл ажиллагаа нь хүндэрсэн гэсэн хариултыг өгсөн байна.

Хэдийгээр Монголчуудын уламжлалт Цагаан сарын баярын өдрүүдэд нийслэл Улаанбаатар хотод хатуу хөл хорио тогтоож зайлшгүй ажиллах салбаруудаас бусад салбаруудын үйл ажиллагааг хориглосон хэдий ч хөл хорио тогтоох хугацаа хүртэлх эхний 10 хоног болон хөл хориог цуцалсны дараах 5 хоногт ААН-ийн үйл ажиллагаа явуулах идэвх өмнөх сартай харьцуулахад илүү сайжирсан байдал ажиглагдаж байна.

Судалгаанд хамрагдсан ААН-ийн орлого болон үйлдвэрлэл буурч байгаа байдал нь хугацаа өнгөрөх тусам илүү гүнзгийрч байгаа бөгөөд энэ нь 50-иас дээш хувиар орлого болон үйлдвэрлэл нь буурсан ААН-ийн эзлэх хувь тогтмол 60 хувиас давснаар баталгаажиг байгаа юм.

Цаашид Засгийн газраас “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлж, хатуу хөл хорио тогтоох арга хэмжээ авбал ААН-ийн үйл ажиллагаанд “Маш их сөрөг нөлөө үзүүлнэ” гэж судалгаанд хамрагдсан ААН-ийн олонх нь буюу 57.3 хувь нь хариулсан байна.

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО
ЭДИЙН ЗАСГИЙН СТАТИСТИКИЙН ГАЗАР